Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйл

Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйл

Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана.

ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулав.

ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙН БҮТЭЦ



Аравтын зохион байгуулалттай.



Хэсгийн зохион байгуулалттай.



АЙМАГ, СУМ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ХИЛИЙН ЦЭС, БАГ, ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРИЙН ЗААГ ТОГТООХ



ИРГЭДИЙГ ОРОЛЦУУЛНА, ТЭДНИЙ САНАЛД ҮНДЭСЛЭНЭ.

- Аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.
- Баг, хорооны нутаг дэвсгэрийн заагийг аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

Монгол Улсын хэмжээнд 1000-аас доош хүн амтай сум 19, аймгийн төвөөс 50 километрийн дотор төв нь байрших сум 43, түүний дотор зэргэлдээ сумын төвөөсөө 5-25 километрийн зайд төв нь орших сум хэд хэд байгаа нь засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээний зардлын үрэлгэн байдлыг бий болгож байна.

Эх сурвалж: ЗЗНДНТУТХ-ийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээний тайлан.

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖИЙГ ӨӨРЧЛӨХ

- Аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлыг зөвхөн Засгийн газар санаачилна.
- Баг, хороог өөрчлөх асуудлыг аймаг, нийслэлийн Засаг дарга өргөн мэдүүлснээр аймаг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг шийдвэрлэхдээ иргэдийн санал авах ажлыг харьяалах иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хариуцан зохион байгуулах бөгөөд санал авах журмыг Улсын Их Хурал тогтооно.

Харгалзах үзүүлэлт:



орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх



хүн амын болон газар зүйн байршил

тэдгээртэй холбогдох бусад нөхцөл

ОРОН НУТГИЙН ЧИГ ҮҮРЭГ

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ:

- Нутгийн өөрийн удирдлага = Орон нутгийн бие даасан байдал
- Нэгж дэх төрийн удирдлага = Төрийн хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, орон нутгийн үйл ажиллагаан дахь төв засгийн хяналт

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрийн чиг үүргийг тодорхой болгосон. Ингэснээр нэгжүүдийн чиг үүрэг хоорондоо холилдох, давхцах зэрэг сөрөг үр дагавар арилна.

Чиг үүргийг удирдлагын субъектаар бус, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр хуваарилах зарчмыг баримтлав. Ингэхдээ иргэдэд хамгийн ойр нэгжийг сум, дүүрэг гэж үзэн тус нэгжүүдийн эрх, чиг үүргийг нэмэгдүүлсэн.

ЗЗНДНТУТХ-д орон нутгийн чиг үүргийг тодорхойлсны дагуу Төсвийн тухай хуульд заасан чиг үүргийн жагсаалтыг хүчингүй болгох замаар ангиллыг нэгдмэл болгож, чиг үүргийн санхүүжилтийн асуудлыг тодорхой болгов.

Эдийн засаг, төсвийн талаар орон нутаг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал
- орон нутгийн өмчийн удирдлага
- орон нутгийн төсөв, татвар, төлбөр, хураамж
- орон нутгийн сан

Бодлого тодорхойлж, хэрэгжүүлэх талаар орон нутаг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- орон нутгийн боловсон хүчний асуудал
- орон нутгийн хүн амын эрүүл мэндийн асуудал
- орон нутгийн нийгэм, соёлын асуудал
- орон нутгийн байгаль орчны асуудал
- орон нутгийн дэд бүтцийн хөгжлийн асуудал
- үйлдвэрлэл, хүнс, хөдөө аж ахуйн асуудал

Үйлчилгээ, аж ахуйн талаар орон нутаг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- боловсролын байгууллагын барилга байгууламж
- эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж
- орон нутгийн харьяалалтай биеийн тамир, спортын барилга байгууламж
- орон нутгийн чанартай номын сан, музей, театр, соёлын төвийн барилга байгууламж
- инженерийн шугам сүлжээ, суваг шуудуу
- орон нутгийн цэвэрлэх байгууламж
- орон нутгийн зам, гүүр
- орон нутгийн суурин газрын гэрэлтүүлэг

Зохицуулалтын шинжтэй дараах чиг үүргийг орон нутаг хэрэгжүүлнэ:

- хүн амын унд, ахуйн хэрэгцээний ус хангамж
- худалдаа, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ
- орон нутгийн чанартай нийтийн тээвэр, такси үйлчилгээ
- хот суурингийн замын хөдөлгөөн, авто зогсоол
- гудамж, талбай, барилга, байшингийн хаягжилт
- хөшөө дурсгалын байршил, хамгаалалт
- хот тохижилт, явган хүн, тоглоомын талбайн байгууламж
- олон нийтийн амралт, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж
- орон нутгийн чанартай аялал жуулчлалын менежмент
- орон нутгийн чанартай бэлчээрийн менежмент

ОРОН НУТГИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГЫН ХЯНАЛТЫН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг хариуцлагажуулах, орон нутагт улс төржилтийг хязгаарлах зохицуулалтыг бий болгов.



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫГ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛААС СОНГОЖ БАЙГУУЛНА.

Аймаг нийслэлийн Засаг дарга нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг тараах саналыг Засгийн газарт оруулна.

Төлөөлөгчийн үүргээ биелүүлэхгүй байгаа гэсэн үндэслэлээр тухайн тойргийн сонгогчдын олонхын саналаар төлөөлөгчийг эгүүлэн татна.

Сумын иргэдийн Төлөөлөгчийн Хурлын сонгуульд улс төрийн нам нэр дэвшүүлж оролцохгүй.

Улс төрийн нам, эвсэл иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүтцэд аливаа хэлбэрээр нэгж байгуулахгүй

Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны чөлөө цагт Хурлын Тэргүүлэгчид Хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлж байсан буруу жишгийг халж, Хурал асуудлыг бүрэн бүрэлдэхүүнээр шийдвэрлэх хамтын удирдлагын байгууллага гэсэн шинжийг хуулийн төсөлд тодотголоо.



НУТГИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГАД ИРГЭД ШУУД ОРОЛЦОХ

- Баг, хорооны иргэдийн Нийтийн Хуралд саналын эрхтэй оролцох
- ИТХ, ИНХ-д хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр санал гаргах
- Сум, баг, дүүрэг, хороо, аравт, хэсгийн тулгамдсан асуудлыг хэлэлцэх, зөвлөмж гаргах зорилгоор сонгуулийн эрх бүхий иргэд сайн дураараа хамтарч үзэл бодол, хүсэл зоригоо илэрхийлэх
- Нэг удаагийн, эсхүл хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахыг санаачлах



ЗАСАГ ДАРГЫГ ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ, ОГЦРУУЛАХ ЗОХИЦУУЛАЛТ



ТОМИЛОХ

- Засаг даргыг томилуулахаар тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Нийтийн Хурал нэр дэвшүүлнэ.
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, иргэдийн Нийтийн Хуралд оролцогч дангаараа буюу хамтарч, түүнчлэн дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд нэр дэвшүүлэх санал гаргаж болно.
- Бүх шатны Засаг даргад нэр дэвшигч нь хуульд заасан шаардлагыг хангасан байна.
- Баг, хорооны Засаг даргаар сум, дүүргийн Засаг дарга; сум, дүүргийн Засаг даргаар аймаг, нийслэлийн Засаг дарга; аймаг, нийслэлийн Засаг даргаар Ерөнхий сайд тус тус томилно.

ЧӨЛӨӨЛӨХ

Засаг дарга эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлт гаргасан бол дээд шатны Засаг дарга буюу Ерөнхий сайд түүнийг бүрэн эрхийнх нь хугацаа дуусахаас өмнө үүрэгт ажлаас нь чөлөөлнө.

ОГЦРУУЛАХ

Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд хуульд заасан үндэслэлээр зохих шатны Хурлын санал, эсхүл өөрийн санаачлагаар Засаг даргыг огцруулах шийдвэр гаргана.

Хариуцлага тооцох үндэслэл:

- Хурлын шийдвэрийн биелэлтийг хангалтгүй биелүүлсэн гэж тухайн Хурал дүгнэсэн бол
- Нутаг дэвсгэрийнхээ нийгэм, эдийн засаг, хүн амын амьдралын асуудалтай холбогдох хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж тухайн Хурал дүгнэсэн бол
- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон Ерөнхий сайд, дээд шатны Засаг даргын өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн гэж дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд үзсэн бол.

ХОТ, ТОСГОНД ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ШИЛЖҮҮЛЭХ

Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх, хүн амын болон газар зүйн байршил, дэд бүтэц, тэдгээртэй холбогдох бусад нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

Хот, тосгонд шилжүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт олгох үүргийг төр хүлээнэ.

Улсын зэрэглэлтэй хот, түүний үндсэн нэгжид энэ хуулийн 21-23 дугаар зүйлд заасан аймаг, сум, багийн зарим чиг үүргийг шилжүүлнэ.

Орон нутгийн зэрэглэлтэй хот, түүний үндсэн нэгжид энэ хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан сум, багийн зарим чиг үүргийг шилжүүлнэ.

Тосгонд энэ хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан сум, багийн хэрэгжүүлэхээр заасан зарим чиг үүргийг шилжүүлнэ.

Хууль тогтоомжид тусгайлан заавал энэ зүйлд зааснаас өөрөөр чиг үүргийг нэг бүрчлэн хот, тосгонд олгож болно.



НЭГЖИЙН УДИРЛАГЫН НИЙГМИЙН БАТАЛГАА

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь авч байсан албан тушаалын 6 сарын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.

- Төрийн албанд 25-аас дээш жил ажилласан аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга тэтгэвэр тогтоолгох бол тэдгээрт урьд нь авч байсан албан тушаалын 12 сарын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тусламж олгоно.

- Хурлын төсөвт төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг тусгана. Зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журмыг Засгийн газар батална.

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газраас тогтоосон хязгаарын хүрээнд Хурал өөрөө тогтооно.

ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэгж тус бүрийн чиг үүрэг, бүрэн эрхийг тодорхой болгов. Орон нутгийн чиг үүргийг өргөжүүлж, тодорхой зааж өгсөн тул тэдгээр чиг үүргийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулиар тодорхой болгох шаардлага үүсч байна. Иймд Төсвийн тухай хуулийн 4.1.30-д заасан “орон нутгийн төсвийн суурь зарлага”-ыг шинээр тодорхойлсон бөгөөд орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх чиг үүргийг Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлд давхардуулан заах шаардлагагүй болно.



Баг нь нутгийн өөрийн удирдлагад иргэдийн оролцоог хангах, иргэдэд засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээ хүргэх анхан шатны нэгж байна. Баг нь аравтын зохион байгуулалттай байна. Аравт, хэсгийн хуваарийг газар нутгийн байршил, хүн амын суурьшил, өрхийн тоог харгалзан иргэдийн Нийтийн Хурал тогтооно.



Сум нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх, иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих үндсэн нэгж байна



Аймаг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, сум хоорондын үйл ажиллагааг зохицуулах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналтыг хэрэгжүүлэх нэгж байна.



Хороо нь иргэдэд засаг захиргааны үйлчилгээ хүргэх, нутгийн өөрийн удирдлагад иргэдийн оролцоог хангах чиг үүрэг бүхий анхан шатны нэгж байна. Хороо нь хэсгийн зохион байгуулалттай байна. Хэсгийн хуваарийг хүн амын суурьшил, өрхийг тоог харгалзан хорооны иргэдийн Нийтийн Хурал тогтооно.



Дүүрэг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, иргэдэд засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах үндсэн нэгж байна.



Нийслэл нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналтыг хэрэгжүүлэх нэгж байна.



Орон нутгийн гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлэхийн тулд нэгжийн орон нутгийн орлогыг дараах байдлаар нэмэгдүүлнэ. Үүнд:



Орон нутгийн төсөвт хамаарах

Сумын нийт татварын орлогын 60 гаруй хувийг суманд үлдээх. Үүнд сумаас аймгийн орлогод одоо төвлөрүүлж байгаа Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвар, газрын төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татвар хамаарна.



Татварын ерөнхий хуулиар шинээр бий болгосон малын тоо толгойн албан татварыг сумын төсвийн орлогод хамааруулж хуульчлах.

Улсын төсөвт хамаарах



Орон нутагт бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн орлогын татварын 40 хувийг аймгийн төсөвт үлдээх.

Ингэснээр орон нутгийн татварын идэвх, санаачлага дээшилж, сумын татварын орлого нэмэгдэх ба тэр хэмжээгээр аймгийн төсвөөс олгодог санхүүгийн дэмжлэг багасч, сумын төсөв дээд шатны төсвөөс хамаарал багатай болж санхүүгийн хувьд харьцангуй бие даах нөхцөл бүрдэнэ. Тус өөрчлөлтөөс хамаарч төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй.

Орлогын төлөвлөгөөнөөс давсан хэсгийг сум өөрөө мэдэж зарцуулах учраас нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлаа бие даан шийдвэрлэх боломж нэмэгдэнэ.

Төсвийн хуулийн 23-р зүйлд өөрчлөлт орсноор аймаг, сум, нийслэл, дүүргийн татварын орлого дараах татваруудаас бүрдэнэ.





Улсын төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:

- аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 60 хувь
- нэмэгдсэн өртгийн албан татвар
- онцгой албан татвар
- гаалийн албан татвар
- авто бензин, дизелийн түлшний албан татвар
- ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
- ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр
- агаарын бохирдлын төлбөр
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 11.2-т заасан улсын тэмдэгтийн хураамж
- ус бохирдуулсны төлбөр
- газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 70 хувь
- 23.4.12.газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 70 хувь

Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:

- Нийслэл хотын албан татвар;
- аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь
- автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
- үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр
- өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар
- хуулиар тусгайлан заасан улсын тэмдэгтийн хураамж
- газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 20 хувь

Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:

- Хувь хүний орлогын албан татвар
- газрын төлбөрийн 60 хувь
- үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
- галт зэвсгийн албан татвар
- хуулиар тусгайлан заасан улсын тэмдэгтийн хураамж
- агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж
- ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж
- байгалийн ургамал ашигласны төлбөр
- ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр
- түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
- хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр
- нохойны албан татвар
- хог хаягдлын үйлчилгээний хураамж

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төсөлд орон нутгийн үндсэн чиг үүргээс гадна төрийн чиг үүргийг орон нутагт шилжүүлж болох тухай заасан. Шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлэх санхүүжилтийг холбогдох сайдын багцаас гэрээний үндсэн дээр орон нутагт шилжүүлж байх зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд тусгасан болно. Ингэснээр санхүүжилт нь тодорхойгүй олон чиг үүргийг орон нутагт салбарын хуулиар нэмж хариуцуулж байгааг өөрчлөх юм.

Төрийн чиг үүргийг шилжүүлэх зохицуулалт бий болсонтой холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан “Засгийн газрын зарим чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх” тухай зохицуулалтыг хүчингүй болгохоор төсөлд тусгасан болно.

Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн зардлыг орон нутгийн төсвийн суурь зарлагад тусгахаас гадна улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгайлан зааж байх талаар Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2-т тусгасан. Ингэснээр орон нутгийн хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах хөрөнгө оруулалт нь аль нэг сайдын багцад биш “орон нутаг” гэсэн тусдаа ангилалаар улсын төсөвт тусгагдаж байх юм. Жишээ нь, ерөнхий боловсролын сургуулийн их засварыг орон нутгийн чиг үүрэгт хамааруулсан тул энэ нь боловсролын салбарын хөрөнгө оруулалт биш орон нутгийн хөрөнгө оруулалт гэж ойлгогдоно.

НЭГЖҮҮДИЙН ӨМЧТЭЙ БАЙХ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛСАН.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧ | АЙМГИЙН ӨМЧ | СУМЫН ӨМЧ | ДҮҮРГИЙН ӨМЧ

ОРОН НУТГИЙН ӨӨРИЙН ӨМЧ → АЛБАН ХЭРЭГЦЭЭНИЙ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ

Аж ахуйн зориулалттай өмчөө хуулийн этгээд байгуулах замаар ашиглах эрхтэй байна. Хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох эрхтэй бөгөөд ингэхдээ гагцхүү өөрийн өмч давамгайлсан компаниар дамжуулан хэрэгжүүлнэ.



ОДООГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА

Монгол улсын нэгдсэн төсвийн татварын орлогод орон нутгийн татварын орлогын эзлэх хувь:

ТАТВАРЫН ОРЛОГО	2016	2017	2018	2019
Монгол Улсын нэгдсэн төсвийн татварын орлого	4,950,950.20	6,315,131.90	8,207,105.30	9,749,060.50
Орон нутгийн төсвийн татварын орлого	799,450.10	1,006,551.40	1,155,160.50	1,133,300.00
Монгол Улсын нэгдсэн төсвийн татварын орлогод эзлэх хувь	16.5	15.9	14.1	17.5

/Эх сурвалж Үндэсний статистикийн хороо/

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогод сүүлийн 4 жилийн байдлаар орон нутгийн төсвийн орлого 14-17 хувийг эзэлж байна. Татварын орлого Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын 80 гаруй хувийг эзэлж байгаа бол орон нутгийн төсвийн орлогын 40 орчим хувийг бүрдүүлж байна.

Сумын орлогын төвлөрүүлэлтийн байдал: Сумдад бий болсон нийт орлогын 44,8 хувь нь аймгийн төсвийн орлогыг, 16,0 хувь нь улсын төсвийн орлогыг, 39,2 хувь нь сумын төсвийн орлогыг бүрдүүлж байна.

/Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2018 оны татварын орлогын гүйцэтгэлээс тооцов/







Жишээлбэл:

Хөвсгөл аймгийн сумдад бий болсон нийт орлогын 48 хувь нь аймгийн төсвийн, 25 хувь нь улсын төсвийн, 27 хувь нь сумын төсвийн орлогыг, Дундговь аймгийн сумдад бий болж буй нийт орлогын 31,8 хувь нь аймгийн төсвийн, 31,9 хувь нь улсын төсвийн, 36,3 хувь нь сумын төсвийн орлогыг бүрдүүлж байна.

/ сая төгрөгөөр/

Аймаг	Сумын нэр	Сумын нийт орлого	ҮҮНЭЭС			Орлого бүрдүүлэлт %		
			Аймгийн төсөвт	Улсын төсөвт	Сумын төсөвт	Аймгийн төсөвт	Улсын төсөвт	Сумын төсөвт
Дундговь	Говь-Угтаал	1,080.7	178.2	822.9	79.5	16.5	76.1	7.4
	Дэлгэрхангай	298.2	107.2	102.0	89.0	35.9	34.2	29.8
	Цагаандэлгэр	85.7	62.6	2.2	20.8	73.0	2.6	24.3
Хөвсгөл	Тариалан	745.8	302.9	250.1	192.8	40.6	33.5	25.9
	Мөрөн	11,920.4	5,997.9	4,003.5	1,918.8	50.3	33.6	16.1
	Цагаан нуур	160.5	95.4	5.9	59.1	59.4	3.7	36.8

/6 сумын орлого төвлөрүүлэлтийн байдал 2019 оны гүйцэтгэлээр жишээ болгон авав./

Улсын төсөвт төвлөрүүлж байгаа аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

/сая төгрөг /

Аймаг	2017	2018
Баян-Өлгий	562.3	534.8
Говь-Алтай	177.	191.
Завхан	161.6	137.
Увс	213.4	440.7
Ховд	246.7	456.5
Архангай	298.5	319.3
Баянхонгор	345.2	553.
Булган	227.4	282.8
Орхон	2,257.5	2,856.8
Өвөрхангай	581.3	1,100.
Хөвсгөл	380.9	497.7
Говьсүмбэр	183.	209.8
Дархан-Уул	2405.9	2497.6
Дорноговь	675.9	912.1
Дундговь	250.6	507.2
Өмнөговь	4599	5461.9
Сэлэнгэ	821.5	924.8
Төв	1,883.	4,392.5
Дорнод	782.	1,000.
Сүхбаатар	179.7	326.9
Хэнтий	268.4	573.7
Аймгийн дүн	17,500.8	24,176.1
Улаанбаатар	26,455.5	45,605.4
Улсын дүн	43,956.3	69,781.5

Эх сурвалж: Татварын ерөнхий газар

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар: аймгууд 2017 онд 17.5 тэрбум, нийслэл 26.4 тэрбум, 2018 онд аймгууд 24.1 тэрбум, нийслэл 45.6 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Татварын орлогын тодорхой хэсгийг орон нутагт үлдээснээр улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг буурч, орон нутаг эдийн засгаа хөгжүүлэх идэвхи санаачлага дээшилнэ.



Аймгийн төсвөөс сумын төсөвт олгож байгаа санхүүгийн дэмжлэг, сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлж байгаа орлого

Аймаг	Суманд олгож байгаа санхүүгийн дэмжлэг	Сумаас аймагт төвлөрүүлж байгаа орлого
Архангай	5065.4	5580.3
Баянхонгор	13321.6	6007.4
Баян-Өлгий	8039.6	6905
Булган	4717.2	20706.7
Говь-Алтай	11095.5	3580
Дорноговь	5329.5	14225.2
Дорнод	6559	11789
Дундговь	8110.6	3961.3
Завхан	5773	2881.7
Өвөрхангай	12947.9	7676.9
Сүхбаатар	4090.9	6214.7
Сэлэнгэ	13737.5	16215.8
Төв	16064.8	13619.6
Увс	12284.4	6200.5
Ховд	10130.3	6974.7
Хөвсгөл	6492.6	8342.7
Хэнтий	6055.1	6794.7
Говьсүмбэр	2417.5	4256.8
Дархан-Уул	3126.2	19483.2
Орхон аймаг	3028.1	52671
Өмнөговь	9611.3	85493

Эх сурвалж . Аймгуудын ИТХ-ын хуралдааны 2019 оны орон нутгийн төсөв баталсан тогтоол





ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР:

- Үндсэн хуулийн нутгийн удирдлагатай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаатай бүрэн нийцнэ.
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын эрх зүйн орчин боловсронгуй болно.
- Хууль хоорондын уялдаа сайжирч, хэрэгжилт нэг мөр хангагдах нөхцөл бүрдэнэ.



ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ